

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/335/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Ж.Болормаа
Утас: 261740 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

Амгалан Ахуй Аудит ХХК-ийн захирал Д.Амгалан
Утас: 77011044 Цахим хаяг: amgaaubg@gmail.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Д.Дэлгэрэхжаргал
Утас: 77011044 Цахим хаяг: degi0418@gmail.com

Аудитор Б.Буянтэгш
Утас: 77011044 Цахим хаяг: buyan.audit@gmail.com



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Бараа материалын талаар	4
2.9.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	5
3	Менежментийн захидал	6
3.1	Бараа материалын талаар	7
3.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	7
3.4	Санхүүгийн тайлангийн хугацааны талаар	7
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ
ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.БАТДОРЖ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүгнэлтэд өгсөн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн дарга Ц.Батдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд уг байгууллага нь “Acolous” програмыг сайжруулж, шинэчлэлт хийж, бүрэн ашиглаж үйл ажиллагаандаа нэвтрүүлж санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 05-наас 2018 оны 2 дугаар сарын 21-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Амгалан Ахуй

Аудит ХХК-ийн Захирал Д.Амгалан, аудитор Б.Буянтэгш, Б.Цэцэгмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 3/319 дугаар албан бичгээр “Амгалан Ахуй Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн А/139 дүгээр тушаалаар Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн дүрэм, бүтцийг 13 орон тоотойгоор баталсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Монгол Улс болон гадаадад албан ба албан бус сургалт, амьдрах орчноос чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, мэргэшсэн үнэлгээчнийг бэлтгэх, судалгаа шинжилгээний ажил эрхлэх, Чадамжинд суурилсан сургалтын стандарт хөтөлбөрт зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах, үнэлгээний багц, сургалтын хэрэглэгдэхүүн, инновацийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлж, мэргэшлийн түвшинг үнэлэх, гэрчилгээжүүлэх, баталгаажуулах, үнэлгээний ажилтанг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, судалгаа шинжилгээ хийх, салбарын инновацийг хөгжүүлэх, чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, цахим мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхээр зорилт тавьсан.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн эрхэм зорилго нь

Техник мэргэжлийн боловсрол сургалтын чанарын хяналт, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, МБСБ-ын төгсөгч болон иргэдийг үнэлгээний үйлдвэр хатан, чанартай шуурхай үйлчилгээгээр хангаж, олон улсын жишигт нийцсэн үндэсний мэдээллийн сан бүрдүүлэхэд оршино.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн

тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 18 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.


Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн шууд захирагчид 2017 онд нийт 229,660.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Үүнээс урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 110,996.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлэх нь 118,664.8 мянган төгрөг батлагдсанаас 94,870.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн 23,794.8 мянган төгрөгөөр тасалдуулсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан дөнгөж харуулсан. Албан томилолт зардлыг 7,200.0 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 13,280.2 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдолтой зардлыг 3,368.8 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй байна.



2.7 Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн нь шилэн дансны мэдээлэлтэй танилцахад Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуулийн тогтоосон хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байх ба хугацаандаа мэдээлсэн 3, хугацаа хоцроож мэдээлсэн 13, нийт 16 мэдээлэл байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээлэл 2 байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Бараа материалын талаар

Хяналтын тооллого хийхэд 151.5 мянган төгрөгийн 101 ширхэг чадамжийн гэрчилгээний хавтас дутагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

2.9.2 Биет бус хөрөнгийн талаар

Хөрөнгийн ашиглалт хангалтгүй, санхүүгийн мэдээлэл боловсруулалтын төлөвлөлт, журамгүй байсан.


Тус байгууллагын санхүүгийн програм хангамжийг сайжруулж шинэчлэлт хийж Санхүүгийн тооцоолохын “Acolous” програмыг 880.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч бүрэн ашиглаж үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бүрэн хангалттай ашиглахын тулд шаардлагатай сургалтанд хамрагдаж санхүүгийн тайлан, тодруулга, бусад мэдээллээр удирдлагыг хангаж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.3 Санхүүгийн тайлангийн талаар

2017 оны Санхүүгийн тайлангаа Аудитын байгууллагад 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэн өгсөн нь Төрийн Аудитын Тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалт (...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...) гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн Аудитын Тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.



2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 онд өөрийн үйл ажиллагаанаас олох орлогыг 118,664.8 мянган төгрөг төсөвлөснөөс 94,870.0 мянган төгрөг татан төвлөрүүлсэн нь Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 23,794.8 мянган төгрөгөөр тасалсан байна.

Өөрийн үйл ажиллагааны орлого олж түүнийг үйл ажиллагааныхаа зардалд санхүүжүүлэхийг төсвөөр баталж өгсөн боловч Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн орлого олох, зарцуулах журам, үйлчилгээний үнэ тогтоох журмыг холбогдох дээд шатны байгууллага баталж өгөөгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн Мянган сорилын сангаас санхүүжүүлсэн Монгол Солонгосын коллежийн дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгийг Төрийн Өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүй тул 2017 оны санхүүгийн тайланд анхаарч үзэх нь зүйтэй.

Тус байгууллага нь шинээр зохион байгуулагдсан бөгөөд онцлох асуудалд дурьдсан журмууд батлагдаагүй байгаагаас шалтгаалан орлогыг бүртгэж тайлагнах үйл явцыг цаашид анхаарах шаардлагатай.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1 төрлийн 880.0 мянган төгрөгийн зөвлөмжийг, 2 төрлийн 151.5 мянган төгрөгийн албан шаардлагын тус тус хүргүүлсэн ба нийт 3 төрлийн 1,084.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн. Цаашид дээрх зөрчлийг давтахгүй байх талаар анхаарч ажиллахыг зөвлөж байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.


2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

2017 оны материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцохоор болов. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар буюу 2,521.6 мянган төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталж зөвлөмжийг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэн гүйцэтгэсэн.



2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын санхүүгийн програм хангамжийг сайжруулж шинэчлэлт хийж Санхүүгийн тооцоолохын “Acolous” програмыг 880.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч бүрэн ашиглаж үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлэх Бүрэн хангалттай ашиглахын тулд шаардлагатай сургалтанд хамрагдаж санхүүгийн тайлан, тодруулга, бусад мэдээлэлээр удирдлагыг хангаж ажиллах тухай зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл сайжрахгүй
Удирдлагын шийдвэр гаргалтанд нөлөөлнө
Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл хуулиар заасан цаг хугацаанд гарахгүй.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫНТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	211,750.00	6,985,788.00
33	АВЛАГА	-	26,858.00
3361	Бусад авлага	-	26,858.00
336101	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	26,858.00
35	БАРАА МАТЕРИАЛ	211,750.00	6,958,930.00
35400	Хангамжийн материал	211,750.00	6,958,930.00
35410	Бичиг хэргийн материал	211,750.00	5,830,800.00
35430	Сэлбэг хэрэгмэл	-	341,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	286,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	501,130.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,900,621.69	949,520,695.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,900,621.69	949,520,695.48
392	Биет хөрөнгө	7,900,621.69	948,830,139.48
39201	Барилга, байгууламж	-	935,688,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	12,995,666.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	38,633,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	20,389,638.88
39205	Машин тоног төхөөрөмж	8,944,100.00	9,874,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	1,043,478.31	1,979,554.94
393	Биет бус хөрөнгө	-	690,556.00
39301	Програм хангамж	-	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	189,444.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,112,371.69	956,506,483.48
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,500.80
41300	Өглөг	-	8,500.80
41362	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	8,500.80
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,112,371.69	956,497,982.68
51	Засгийн газрын хувь оролцоо	8,944,100.00	8,944,100.00
51101	Засгийн газрын оруулсан капитал	8,944,100.00	8,944,100.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-	947,553,882.68
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	831,728.31
VIII	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,112,371.69	956,506,483.48

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111,095,404.00	1,200,547,750.00
II	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,755,710.00	1,089,551,650.00
12	Нийтлэг татварын бус орлого	10,755,710.00	1,089,551,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	94,870,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,755,710.00	
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		39,659,150.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		955,022,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,339,694.00	110,996,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	100,339,694.00	110,996,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	100,339,694.00	110,996,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	111,927,132.31	252,162,139.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,087,336.31	252,162,139.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,087,336.31	241,540,937.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,300,914.00	143,350,123.00
210101	Үндсэн цалин	91,300,914.00	143,350,123.00
	Нэмэгдэл	-	-
	Урамшуулал	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,043,094.00	15,814,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,391,069.00	10,063,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	730,407.00	1,437,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	912,996.00	1,150,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	182,601.00	287,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,826,021.00	2,875,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой зардал		2,361,815.00
210301	Цэвэр, бохир усны зардал		98,400.00
210302	Түлш, халаалтын зардал		2,263,415.00
2104	Хангамж, бараа материалын зардал	699,850.00	19,878,412.80
210401	Бичиг хэрэг	699,850.00	13,525,790.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,625,250.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	-	581,250.00
210404	Бага үнэтэй, түргэн элэгдэл зүйлс		22,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгах		1,923,422.80
2107	Томилолт, зочны зардал		15,225,800.00
210701	Дотоод албан томилолт	-	15,225,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	11,023,460.00
210801	Тээврийн хэрэгслийн татвар	-	60,500.00
210802	Даатгалын үйлчилгээний зардал	-	473,100.00
210804	Улсын мэдээллийн маягтын зардал	-	9,750,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		739,860.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,043,478.31	33,886,826.21
210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	18,692,000.00
210902	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,043,478.31	15,194,826.21
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,839,796.00	10,621,202.00
	Бусад урсгал шилжүүлэг	773,994.00	3,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	773,994.00	
213210	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,900,000.00
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,065,802.00	6,721,202.00
213209	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,065,802.00	6,721,202.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	- 831,728.31	948,385,610.99
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	- 831,728.31	948,385,610.99



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн				
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,944,100.00		(831,728.31)	8,112,371.69
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,944,100.00		(831,728.31)	8,112,371.69
Тайлант үеийн үр дүн			948,385,610.99	948,367,253.79
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,944,100.00		947,553,882.68	956,497,982.68



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111,095,404.00	245,525,250.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,755,710.00	134,529,150.00
	Нийтлэг татварын бус орлого	10,755,710.00	134,529,150.00
1200041	Туслах үйл ажиллагааны орлого		
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлого	10,755,710.00	94,870,000.00
1200043	Гадаад эх үүсвэрийн санхүүжилт	-	39,659,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,339,694.00	110,996,100.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	100,339,694.00	110,996,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	100,339,694.00	110,996,100.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН II	102,255,608.00	245,525,250.00
	УРСГАЛ ЗАРДАЛ	111,095,404.00	245,525,250.00
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,255,608.00	234,904,048.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,300,908.00	143,350,123.00
210101	Үндсэн цалин	91,300,908.00	143,350,123.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Урамшуулал	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,043,100.00	15,814,500.00
210201	Тэтгэврийн даатгал	10,043,100.00	15,814,500.00
201202	Тэтгэмжийн даатгал	-	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	-
210204	Ажилгүйдлийн даатгал	-	-
210205	Эрүүл мэндийн даатгал	-	-
	Байр ашиглалттай холбоотой зардал		2,361,815.00
210304	Цэвэр, бохир усны зардал		98,400.00
210305	Түлш, халаалтын зардал		2,263,415.00
	Хангамж, бараа материалын зардал	911,600.00	20,531,350.00
210401	Бичиг хэрэг	911,600.00	14,147,200.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,911,250.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	-	581,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэл зүйлс	-	1,668,950.00
210407	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгах		222,700.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,590,900.00
210601	Урсгал засварын зардал	-	1,590,900.00
	Томилолт, зочны зардал		15,225,800.00
210703	Дотоод албан томилолт		15,225,800.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,153,460.00
210801	Тээврийн хэрэгслийн татвар	-	60,500.00
210802	Даатгалын үйлчилгээний зардал	-	473,100.00
210803	Улсын мэдээллийн маягтын зардал	-	15,000,000.00
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,619,860.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,876,100.00
210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	18,876,100.00

210902	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,839,796.00	10,621,202.00
	Бусад урсгал шилжүүлэг	773,994.00	3,900,000.00
213209	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	773,994.00	-
213210	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,900,000.00
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,065,802.00	6,721,202.00
213102	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,065,802.00	6,721,202.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
ЭВ ДТ (31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
ЭХ ДТ (31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,760,900.0	199,144,898.0	26,616,002.0	88.2
II	УРСГАЛ ЗАРДАЛ	225,760,900.0	195,244,898.0	30,516,002.0	86.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,178,000.0	36,080,275.0	30,097,725.0	54.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,768,400.0	143,350,123.0	418,277.0	99.7
210101	Үндсэн цалин	143,768,400.0	143,350,123.0	418,277.0	99.7
210102	Нэмэгдэл	-	-	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-
210104	Урамшуулал	-	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,814,500.0	15,814,500.0		100.0
210205	Тэтгэврийн даатгал	15,814,500.0	15,814,500.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,642,000.0	2,361,815.0	13,280,185.0	15.1
210304	Гэрэл цахилгаан	2,970,000.0		2,970,000.0	-
210304	Түлш, халаалт	7,920,000.0	2,263,415.0	5,656,585.0	28.6
210304	Цэвэр, бохир ус	4,752,000.0	98,400.0	4,653,600.0	2.1
2104	Хангамж, бараа материалын зардал	16,013,200.0	12,651,400.0	3,361,800.0	79.0
210401	Бичиг хэрэг	4,950,000.0	6,267,250.0	-1,317,250.0	126.6
210402	Тээвэр, шатахуун	5,940,000.0	3,911,250.0	2,028,750.0	65.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.0	581,250.0	2,982,750.0	16.3
210406	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал	222,700.0	222,700.0	-	100.0
210407	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,336,500.0	1,668,950.0	-332,450.0	124.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,980,000.0	1,590,900.0	389,100.0	80.3
210601	Багаж, техник хэрэгсэл	1,980,000.0	1,590,900.0	389,100.0	80.3
210604	Урсгал засвар	-	-	-	-
	Томилолт, зочны зардал	9,405,000.0	2,138,600.0	7,266,400.0	22.7
210702	Дотоод албан томилолт	9,405,000.0	2,138,600.0	7,266,400.0	22.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,147,800.0	17,158,460.0	4,994,340.0	77.4
210801	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	495,000.0	-	495,000.0	-
210802	Даатгалын үйлчилгээ	594,000.0	473,100.0	120,900.0	79.6
210803	Тээврийн хэрэгслийн татвар	118,800.0	60,500.0	58,300.0	50.9
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,940,000.0	1,619,860.0	4,320,140.0	27.3
210805	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,000,000.0	15,000,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.0	184,100.0	805,900.0	18.6

210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	990,000.0	184,100.0	805,900.0	18.6
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,900,000.0	-3,900,000.0	
	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	
	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-		-	
	Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.0	-3,900,000.0	
	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-			
213210	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,900,000.0	-3,900,000.0	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	229,660,900.0	201,966,100.0	27,694,800.0	87.9
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,996,100.0	107,096,100.0	3,900,000.0	96.5
213102	Улсын төсвөөс санхүүжих	110,996,100.0	107,096,100.0	3,900,000.00	96.5
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	118,664,800.0	94,870,000.0	23,794,800.00	79.9
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,664,800.0	94,870,000.0	23,794,800.00	79.9
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	

